



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2025 оны эхний хагас жилд 5.1 их наяд төгрөг болж, 4.9 (95.9%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 206.9 (4.1%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2025 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 1.1 (29.1%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.4 (38.8%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр






Төрөл	Жил			Эхний хагас жил			2025* I-VI 2024 I-VI	
	2022	2023	2024	2023 I-VI	2024 I-VI	2025* I-VI	зөрүү	хувь
	тэрбум төгрөг							
Нийт	6 758.7	7 977.9	9 158.4	3 160.7	3 921.7	5 061.7	1 140.0	29.1
Дотоодын байгууллага	6 304.4	7 402.6	8 136.0	2 909.4	3 498.2	4 854.9	1 356.7	38.8
Төрийн	128.9	132.3	99.0	27.3	31.9	509.0	477.0	15.9**
Хувийн	6 128.3	7 210.1	7 986.3	2 853.4	3 440.9	4 322.8	881.9	25.6
Гадаадтай хамтарсан	47.2	60.3	50.7	28.7	25.3	23.1	-2.2	- 8.7
Гадаадын байгууллага	454.4	575.3	1 022.5	251.3	423.6	206.9	-216.7	- 51.2

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 4.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 881.9 (25.6%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 509.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 477.0 (15.9 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өсөж, гадаадтай хамтарсан байгууллагынх 23.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (8.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.



Энэ оны эхний хагас жилд барилга угсралт, их засварын ажлын 37.3 хувийг орон сууцны барилга, 32.6 хувийг орон сууцны бус барилга, 26.0 хувийг инженерийн барилга, байгууламж, 4.2 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс инженерийн барилга, байгууламжийнх 1.6 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 0.7 нэгж хувиар буурсан бол их засварын ажлынх 2.0 нэгж хувиар, орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ
/ХУВИАР/





БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР




ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, барилгын төрлөөр

Төрөл	Жил			Эхний хагас жил			2025* I-VI 2024 I-VI	
	2022	2023	2024	2023 I-VI	2024 I-VI	2025* I-VI		
	тэрбум төгрөг						зөрүү	хувь
Орон сууцны бус барилга	2 059.5	2 811.4	3 031.6	1 207.4	1 303.3	1 648.4	345.1	26.5
Үйлдвэрийн	990.1	1 179.9	1 123.2	574.9	526.9	471.1	- 55.8	- 10.6
Худалдаа, үйлчилгээний	194.1	313.8	378.4	109.5	172.5	251.3	78.8	45.7
Эмнэлгийн	68.1	130.8	139.2	54.6	50.1	70.0	19.9	39.8
Сургууль, соёлын	422.3	660.2	674.2	260.4	308.8	496.7	187.8	60.8
Бусад	385.0	526.8	716.6	207.9	245.0	359.3	114.4	46.7

Орон сууцны бус барилгын ажил 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 345.1 (26.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Төрлөөр авч үзвэл сургууль, соёлын барилгын ажил 187.8 (60.8%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 114.4 (46.7%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 78.8 (45.7%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 19.9 (39.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол үйлдвэрийн барилгынх 55.8 (10.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2025 оны эхний хагас жилд 2.9 их наяд төгрөгийн барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 58.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 6.9 нэгж хувиар өссөн байна. 2025 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 569.8 тэрбум төгрөг, Дархан-Уул аймагт 242.8 тэрбум төгрөг, Орхон аймагт 209.2 тэрбум төгрөгийн барилгын байгууллагын барилга угсралт, их засварын ажлуудыг тус тус гүйцэтгэсэн нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 48.1 хувийг эзэлж байна.